



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/14

Сүмбэр сум


Хариуцлагатай албан тушаалтан томилох  
болон бэлэн байдалд ажиллах тухай

Сонгуулийн тухай хуулийн 89 дүгээр зүйл, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны 4/8204 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Их Хурлын болон Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үйл ажиллагааны бэлтгэл хангах буюу санал авах өдрийн үйл ажиллагаатай холбогдуулан 6 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд сумдын түвшинд итгэмжлэгдсэн ажилтны үйл ажиллагааг хариуцан ажиллах хариуцлагатай албан тушаалтнуудыг хавсралтаар томилон ажиллуулсугай.


2. Сумдын сонгуулийн хэсгийн санал авах байранд ажиллаж буй итгэмжлэгдсэн ажилтануудтай 2 цаг тутам холбогдож түүнээс ирүүлсэн мэдээ, мэдээлэл, асуудлыг газрын даргад шуурхай танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулж, холбогдох арга хэмжээг авч, ажиллахыг сум хариуцсан хариуцлагатай албан тушаалтануудад, мөн газрын бусад албан хаагчдыг дээрх өдрүүдэд байнгын бэлэн байдалд ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЦЭЛМЭГ

2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн  
даргын А/14 тоот тушаалын хавсралт



Говьсүмбэр аймгийн УБСГ-аас сумдыг хариуцан ажиллах хариуцлагатай  
албан хаагчдын нэрс, холбогдох мэдээлэл

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Хариуцан ажиллах сум/дүүрэг	И-мэйл хаяг	Холбоо барих утас
1.	Я.Отгонбаяр	Статистикийн хэлтсийн дарга	Баянтал	<a href="mailto:otgoo_qvs@yahoo.com">otgoo_qvs@yahoo.com</a>	9565-2314
2.	З.Баяндугар	Бүртгэлийн хэлтсийн дарга	Сүмбэр	<a href="mailto:z.bayandugar@yahoo.com">z.bayandugar@yahoo.com</a>	9929-7097
3.	Э.Ганбаатар	МТА	Шивээговь	<a href="mailto:ganaa_enkhbaatar@yahoo.com">ganaa_enkhbaatar@yahoo.com</a>	9983-5969